

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШУА	Шинжлэх Ухааны Академи

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ
ХҮРЭЭЛЭНГИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.ЗОЛБОО ТАНАА

2021.02.25 № 07/543
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 26 зорилтын хүрээнд 41 ажил, үйлчилгээ, тусгай захиалгат 2 ажлын арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.94 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,585,926.70	73,791,030.17
35	Бараа материал	31,585,926.70	73,791,030.17
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,928,177.28	62,447,816.38
392	Биет хөрөнгө	23,658,906.45	62,247,295.59
39201	Барилга, байгууламж	366,740.00	366,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(91,685.04)	(183,370.08)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	33,908,194.00	66,880,354.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,970,767.83)	(20,389,014.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,510,230.00	15,510,230.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,379,837.58)	(10,585,646.30)
39217	Номын фонд	8,316,032.90	10,648,002.90
393	Биет бус хөрөнгө	269,270.83	200,520.79
39301	Програм хангамж	1,045,000.00	1,045,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(775,729.17)	(844,479.21)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	55,514,103.98	136,238,846.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	55,514,103.98	136,238,846.55
51	Засгийн газрын хувь оролцоо	55,514,103.98	136,238,846.55
511	Засгийн газрын оруулсан капитал	60,364,169.48	60,364,169.48
512	Хуримтлагдсан үр дүн	(5,358,357.20)	75,366,385.37
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,358,357.20)	(5,358,357.20)
51220	Тайлант үеийн үр дүн	-	80,724,742.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	508,291.70	508,291.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	55,514,103.98	136,238,846.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	572,715,639.00	840,872,270.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	742,500.00	45,443,170.00
120	Нийтлэг татварын бус орлого	742,500.00	45,443,170.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	742,500.00	45,443,170.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	742,500.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	31,551,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	13,891,570.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	571,973,139.00	795,429,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,570,139.00	777,916,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	527,046,300.00	777,916,300.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	(476,161.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,403,000.00	17,512,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	45,403,000.00	16,810,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	702,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	573,898,256.60	760,147,527.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	573,898,256.60	760,147,527.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	572,178,256.60	712,270,542.04
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	457,595,657.00	584,876,278.00
210101	Цалин	417,233,248.00	584,876,278.00
210102	Нэмэгдэл цалин	40,362,409.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,759,210.00	73,290,280.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,187,604.00	50,368,973.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,610,895.00	5,935,812.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,665,674.00	4,646,668.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	831,086.00	1,121,710.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,463,951.00	11,217,117.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,562,347.50	10,239,749.61
210401	Бичиг хэргийн материал	2,086,597.50	415,055.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,334,945.00	1,288,116.61
210404	Ном, хэвлэлийн зардал	787,892.00	6,213,354.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,352,913.00	2,323,224.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,000,000.00
210604	Урсгал засвар	-	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	38,924,398.91	19,900,203.53

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,424,398.91	18,400,203.53
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,336,643.19	17,964,030.90
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	4,280,280.00	6,183,970.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,056,363.19	11,780,060.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,720,000.00	47,876,985.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,720,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,720,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	47,176,985.39
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	47,125,185.39
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлэг	-	51,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(1,182,617.60)	80,724,742.57
VI	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(1,182,617.60)	80,724,742.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	573,191,800.00	795,429,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	742,500.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	742,500.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	742,500.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	742,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	572,449,300.00	795,429,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	527,046,300.00	777,916,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	527,046,300.00	777,916,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,403,000.00	17,512,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	45,403,000.00	16,810,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	702,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	568,953,311.00	759,020,970.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568,953,311.00	759,020,970.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	566,757,150.00	711,143,984.61
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	453,329,506.00	584,876,278.00
210101	Үндсэн цалин	360,278,135.00	398,040,305.00
210102	Нэмэгдэл	74,403,371.00	149,705,197.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,648,000.00	37,130,776.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	56,244,033.00	73,290,280.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,510,788.00	50,368,973.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,658,168.00	5,935,812.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,286,920.00	4,646,668.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	692,957.00	1,121,710.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,095,200.00	11,217,117.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,472,000.00	25,173,516.61
210401	Бичиг хэрэг	876,645.00	931,495.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,334,945.00	1,090,916.61
210404	Ном, хэвлэл	3,307,492.00	22,387,930.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	952,918.00	763,175.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,623,800.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	623,800.00
210604	Урсгал засвар	-	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,064,511.00	14,856,140.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	42,564,511.00	13,356,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,647,100.00	6,323,970.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,647,100.00	6,323,970.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,196,161.00	47,876,985.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,720,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,720,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	476,161.00	47,176,985.39
213303	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	47,125,185.39
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлэг	476,161.00	51,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,238,489.00	36,408,130.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,238,489.00	36,408,130.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,238,489.00	36,408,130.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,238,489.00	36,408,130.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,238,489.00)	(36,408,130.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

				/төгрөгөөр/
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,364,169.48	508,291.70	(4,175,739.60)	56,696,721.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн		-	(1,182,617.60)	(1,182,617.60)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,364,169.48	508,291.70	(5,358,357.20)	55,514,103.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	80,724,742.57	80,724,742.57
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	60,364,169.48	508,291.70	75,366,385.37	136,238,846.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	777,916,300.00	730,791,114.61	47,125,185.39	93.9
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	777,916,300.00	730,791,114.61	47,125,185.39	93.9
210	Бараа, үйлчилгээний зардал	777,157,800.00	730,091,114.61	47,066,685.39	93.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	614,885,200.00	584,876,278.00	30,008,922.00	95.1
210101	Үндсэн цалин	404,872,000.00	398,040,305.00	6,831,695.00	98.3
210102	Нэмэгдэл	151,501,200.00	149,705,197.00	1,796,003.00	98.8
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	58,512,000.00	37,130,776.00	21,381,224.00	63.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,009,600.00	73,290,280.00	9,719,320.00	88.2
210201	Тэтгэврийн даатгал	58,414,100.00	50,368,973.00	8,045,127.00	86.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,148,900.00	5,935,812.00	213,088.00	96.5
210203	ҮОМШӨ ний даатгал	4,919,100.00	4,646,668.00	272,432.00	94.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,229,800.00	1,121,710.00	108,090.00	91.2
210205	Эрүүл мэндийн даатгал	12,297,700.00	11,217,117.00	1,080,583.00	91.2
2104	Хангамж, бараа материалын зардал	27,839,900.00	27,505,486.61	334,413.39	98.8
210401	Бичиг хэрэг	964,000.00	931,495.00	32,505.00	96.6
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,111,900.00	1,090,916.61	20,983.39	98.1
210404	Ном, хэвлэл	25,000,000.00	24,719,900.00	280,100.00	98.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	764,000.00	763,175.00	825.00	99.8
2106	Эд хогшил худалдан авах	36,000,000.00	36,000,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,381,400.00	2,095,100.00	286,300.00	87.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	881,400.00	595,100.00	286,300.00	67.5
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,041,700.00	6,323,970.00	6,717,730.00	48.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,041,700.00	6,323,970.00	6,717,730.00	48.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	758,500.00	700,000.00	58,500.00	92.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	758,500.00	700,000.00	58,500.00	92.2
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	758,500.00	700,000.00	58,500.00	92.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	777,916,300.00	730,791,114.61	47,125,185.39	93.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	777,916,300.00	730,791,114.61	47,125,185.39	93.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	777,916,300.00	730,791,114.61	47,125,185.39	93.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	37.00	37.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	17,512,800.00	
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	17,512,800.00	
210	Бараа, үйлчилгээний зардал	-	17,461,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	17,461,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	17,461,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	51,800.00	
213101	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	51,800.00	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	17,512,800.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	17,512,800.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	16,810,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	702,800.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг гүйцэтгэх захирал Д.Золбоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Баасанбат, аудитор Ж.Гажидмаа, аудиторын туслах П.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 1/04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн эрхэм зорилго нь Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгийг улс төр дипломатын аргаар хангах, эдийн засаг, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх гадаад таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах талаар суурь судалгаа явуулахад оршино.

Алсын хараа: Гадаад бодлого, орон судлал, олон улсын харилцааны чиглэлд дотоод, гадаадад хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх хүрээлэн, оюуны төв /Think Tank/ болон хөгжихийг эрмэлзэн ажиллана.

Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 7210 Олон улсын харилцаа эдийн засгийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэн нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 369,733.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,697.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурийг хэвээр авч 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 760,147.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,601.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцов.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80,724.7 мянган төгрөгөөр буюу 245.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
	1	2	3=2-1
Б			
Бараа материал	31,585.9	73,791.0	42,205.1
Үндсэн хөрөнгө	23,928.1	62,447.8	38,519.6
Нийт хөрөнгө	55,514.1	136,238.8	80,724.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	55,514.1	136,238.8	80,724.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	55,514.1	136,238.8	80,724.7

Бараа материалын дансны үлдэгдэл 73,791.0 мянган төгрөг болж 42,205.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 24,608.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй ирсэн 31,551.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал болох номыг данс бүртгэлд тусгаж нийт 56,160.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн, 13,763.1 мянган төгрөгийн ном, 192.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 62,447.8 мянган төгрөг болж 38,519.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд урсгал төсвийн хөрөнгөөр 29,376.2 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 4,699.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж (компьютер) худалдан авч, БШУЯ-наас үнэ төлбөргүйгээр шилжиж ирсэн 13,891.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж (компьютер) хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2020 оны 6 дугаар сарын 22-ны А-1/1132 тоот тогтоолоор 14,995.5 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан, үүнтэй холбоотой хуримтлагдсан элэгдэл 4,581.7 мянган төгрөгөөр буурсан. Мөн номын фонд 2,331.9 мянган төгрөгөөр, хуримтлагдсан элэгдэл 1,366.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 136,238.8 мянган төгрөг болж 80,724.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө 38,519.6 мянган төгрөг, бараа материал 42,205.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын оролцоо дансыг өсгөсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 777,916.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 777,916.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 777,916.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 26 зорилтын хүрээний 41 ажил, үйлчилгээ, тусгай захиалгат 2 ажлын хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 777,916.3 мянган төгрөгийн төсөв батлан төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 777,916.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 730,791.1 мянган төгрөгийг зарцуулж 47,125.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 730,791.1 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал зардлыг 30,008.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 9,719.3 мянган төгрөгөөр, бичиг хэрэг, ном худалдан авах зардлыг 334.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр зардлыг 286.3 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 6,717.7 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмжээс 58.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2020 оны төсөвт батлагдсан байсан Монгол, Хятад судлал нэртэй олон улсын хурлын зардал, тухайн хурлын эмхэтгэл хэвлүүлэх зардал, Олон улсын харилцааны хүрээлэнгийн видео танилцуулга, 2020 оны ханын баннерын зардал тус тус дутуу зарцуулагдсан. Нийт төсвийн хэмнэлт нь 2020 онд тэтгэвэрт гарсан ажиллагсад, албан хаагчдын цалин, НДШ, эрдмийн зэрэг цол, төрийн албанд ажилласан, зэрэг дэвийн нэмэгдлүүдийн зөрүү зэргээс бүрджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 3 төслийн санхүүжилт 16,810.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 702.8 мянган төгрөг, нийт 17,512.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 4,065.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 686.4 мянган төгрөг, татварт 438.3 мянган төгрөг, Компьютер дагалдах хэрэгсэлд 4,699.9 мянган төгрөг, хэвлэлтийн зардалд 6,820.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 513.0 мянган төгрөг, принтерийн хор цэнэглэхэд 238.0 мянган төгрөг нийт 17,461.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 51.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлан бүтэн жилээр, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт мэдээлэлүүдийн хугацаа нь болоогүй. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт болох 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Бэмбисан ХХК-д ОУСС 2020, ОУХОнол 2 номын үнэнд шилжүүлсэн 7,161.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шинжлэх ухааны академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн ажлын цагийн бүртгэл хангалтгүй, мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 55-85 насны 63 хүн ажиллаж байна гэсэн зөвлөмжийг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Ажлын цагийн бүртгэл хангалтгүй	1	-	1	-	-	-	100
Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 55-85 насны 63 хүн ажиллаж байна	1	-	1	-	-	-	100

2020 онд ажилтнуудын цагийн бүртгэлийг сайжруулан тухайн хүний нүүрийг таньж цаг бүртгэдэг системд шилжсэн. Тус хүрээлэн нь ажилтнуудын цаг бүртгэлийн төхөөрөмжгүй байсан бөгөөд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу үеийн Референт гараар ажилтнуудын ажлын цагийг бүртгэдэг байсан. Улмаар Захирлын 2020 оны 44 тоот тушаалаар зардал гарган цаг бүртгэлийн төхөөрөмжийг худалдан авч мөн оны 7 дугаар сард цаг бүртгэлийн төхөөрөмж суулган ажиллуулж эхэлсэн. Гэвч зарим саруудад бүрэн гүйцэт бүртгэл хийгдээгүй байгаа нь "Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/169 тоот тушаалын хавсралт “Тусгай горимд шилжин ажиллах журам”, 2020 оны 3 дугаар сарын 10-ны №17 тоот тушаалаар тус тус гэрээс ажилласантай холбоотой. Өндөр насны

тэтгэвэр 10 хүн тогтоолгосон бөгөөд зөвлөмжийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулан 5 хүн ажиллаж байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,109.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,849.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,099.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 7,161.0 мянган төгрөгийн албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 2020 онд худалдан авсан компьютер дагалдах хэрэгслийн элэгдлийг 7 жилээр элэгдүүлэн зардалд дутуу тусгасан 2,377.5 мянга, зурагт, зургийн аппарат, түүний дагалдах хэрэгсэлийг 7 жилээр тооцож илүү тусгасан 528.4 мянга нийт 1,849.1 мянган төгрөгийн зөрүүтэй элэгдлийг тооцоолон залруулав. Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт зэрэг батламж мэдэгдлийг хангаагүйгээс гадна Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын сайдын 2017 оны 02 дугаар сарын 07-ны А/40 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийн Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох баримталсан хугацааны 3.1.1 болон 3.1.3-ыг үндэслэн элэгдлийг тооцох заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн асуудал

Аудитаар 7161,0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд шилэн дансанд байршуулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлан бүтэн жилээр, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гэсэн мэдээлэлүүд байршуулах хугацаа нь болоогүй мөн 5 саяас дээш үнийн дүнтэй худалдан авалт болох 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Бэмбисан ХХК-д ОУСС 2020, ОУХОнол 2 номын үнэнд шилжүүлсэн 7,161.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй байна.

Энэ нь үнэн зөв байдал, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6,099.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, цагийн бүртгэлийн машины ашиглалт болон хөрөнгийн биет тооллого түүвэрлэн хийсэн боловч хөрөнгийн ашиглалтыг хянах нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

И-баримтын нийт 108 гүйлгээ, 81,354.8 мянган төгрөгийн, 55 аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс авсан худалдан авалтыг тулган шалгахад 2021 онд шивэгдсэн 2,558.9 мянган төгрөгийн гүйлгээний зөрүү үүссэн байна.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээ бүртгэж, тайлагнасан байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ хууль тогтоомж, журмын дагуу татварын цахим системд и-баримтыг харилцагч байгууллагуудаар бүрдлийг хангуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

И-баримтын шивэлтийг сар бүр шалгаж ажиллана

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Олон улсын хүрээлэнгийн захирал нь ТҮШУ-5 зэрэглэлээр 1,038.6 мянган төгрөгийн цалинг тогтоосон боловч ШУА-ын ерөнхийлөгчийн 2018 оны тушаалыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгийн цалин, урамшуулал авч байна. 2020 оны нийт цалин, урамшуулал болон НДШ зардлын зөрүүг тооцож үзэхэд 3,540.8 мянган төгрөг байна.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2019 оны 472 болон 276 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээний дагуу ТҮШУ-5 зэрэглэлээр цалинжих заалтыг зөрчиж байна.

2.2. Эрсдэл:

Цалинг илүү тооцож олгох.

2.3. Өгсөн зөвлөмж:

ЗГ-аас баталсан хууль тогтоомжийг судлан дээд байгууллагын гаргасан тушаалтай нийцэж байгаа үгүйг шалган мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

ШУА-н Ерөнхийлөгчийн 2018 оны 9 дүгээр сарын 25-ны Б/49 дугаар тоот тушаалыг үндэслэл болгосон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/81/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэн		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	И-баримтын нийт 108 гүйлгээ, 81,354.8 мянган төгрөгийн, 55 аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс авсан худалдан авалтыг тулган шалгахад 2021 онд шивэгдсэн гүйлгээний зөрүү үүссэн.	2,558.9	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Золбоо Б.Ганчимэг
2	Олон улсын хүрээлэнгийн захирал нь ТҮШУ-5 зэрэглэлээр 1,038.6 төгрөгийн цалинг тогтоосон боловч ШУА-ын ерөнхийлөгчийн 2018 оны тушаалыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгийн цалин, урамшуулал авч байна. 2020 оны нийт цалин, урамшуулал болон байгууллагаас төлөх НДШ зардлын зөрүү үүссэн.	3,540.8	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Золбоо Б.Ганчимэг
3	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа хоцроосон 10 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Энэ 5 саяас дээш үнийн дүнтэй худалдан авалт болох 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Бэмбисан ХХК-д ОУСС 2020, ОУХОнол 2 номын үнэнд шилжүүлсэн мэдээлэл байна.	7,161.0	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Д.Золбоо Б.Ганчимэг
ДҮН		13,260.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 137/А0160058

Улаанбаатар хот

САН- 0061/81/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 151 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, хугацаанд нь бүрэн байршуулж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ШУА-н Олон улсын харилцааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Д.Золбоо, ерөнхий нягтлан бодогч Б.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИЯ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.СЭРЖМЯДАГ

Ч.ЭНХТУЯА

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of numerous horizontal rows, each defined by two parallel dotted lines. The rows are evenly spaced and extend across the entire width of the page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.